

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 13.230, 13.100

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн аюулгүй байдал. Тэсрэлтийн аюулгүй байдал. Ерөнхий шаардлага	MNS 0012-104:202X
Occupational safety and health. Occupational safety. Explosion safety. General requirements.	MNS 0012-104:1994-ийн оронд

Стандарт хэмжил зүйн газрын даргын оны дүгээр сарын ...-ны өдрийн ... дугаар тушаалаар батлав.

Энэ стандарт нь оны.....дүгээр сарын-ний өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Хамрах хүрээ

Энэхүү стандартын шаардлага нь шатамхай хий, уур, тоос, манан, зэрэг тэсрэх чадвартай бодис агуулагдаж болзошгүй үйлдвэр, агуулах болон тэсэлгээний компани хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн ерөнхий шаардлагыг тогтооно.

2 Нэр томъёо, тодорхойлолт

2.1 Тэсрэлт

Хөнөөл үзүүлэх нөлөө бүхий шахагдсан хий, энерги ялгаруулах орчны хурдан хугацааны химийн хувиралт

2.2 Тэсрэлтийн аюулгүй байдал

Тэсрэлт үүсэх боломжийг арилгах үйл ажиллагааны ба тэсрэлт үүсэх нөхцөлд түүнийг зогсоож бий болгох аюултай, хортой хүчин зүйлүүдийн нөлөөллийг зогсоох, материалын үнэт зүйлийг хамгаалах, хадгалалтыг хангах байдал

2.3 Аюулгүй ажиллагааны коэффициент

Үйлдвэрлэлийн үйлажиллагааны даралт, температур, найрлага гэх мэт хэмжигдэхүүний зөвшөөрөгдсөн хэмжээг тооцоход тэсрэлтийн тооны ба туршилтын үнэлгээг засах утга

2.4 Тэсрэлтээс сэргийлэх

Тэсрэлт үүсэх боломжийг зогсоох арга хэмээ

2.5 Тэсрэлтээс хамгаалах

Тэсрэлтийн аюултай ба хортой бодисууд хүмүүст нөлөөлөхийг зогсоох болон материалын үнэт зүйлсийг хамгаалах хадгалалтыг хангах арга хэмжээ.

2.6 Тэсрэх аюултай орчин

2.7 Тэсрэлт үүсэх боломж бүрдсэн химийн идэвхтэй орчин

3. Ерөнхий зүйл

3.1 Зорилго

Энэхүү стандартын зорилго нь тэсрэх орчин үүсч болзошгүй үйлдвэрлэлийн болон хадгалалтын орчинд ажиллаж буй тоног төхөөрөмж, инженерийн систем, технологийн үйл ажиллагааны ерөнхий шаардлагыг тогтоох бөгөөд тэсрэлт үүсэх шалтгаан нөхцөлийг хязгаарлах, тэсрэх орчныг бууруулах, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг хангах, тэсрэлтийн үед хүний амь нас, эрүүл

мэнд, эд хөрөнгөд учирч болзошгүй хохирлыг бууруулах урьдчилан сэргийлэх болон хамгаалалтын зохион байгуулалтын болон техникийн арга хэмжээг тодорхойлоход оршино.

3.2 Ерөнхий шаардлага

3.2.1 Тэсрэлт үүсэх магадлалыг нэг жилийн хугацаанд / 10-6 / -аас хэтрүүлэхгүй байхаар үйлдвэрлэлийн үйл ажиллагааг зохион байгуулна. үйлдвэрлэлийн үйл ажиллагааны онцлог нөхцөл байдал, тодорхой боломжийг үндэслэн ажиллагсад нөлөөлөх тэсрэлтийн аюултай хүчин зүйлийн магадлалыг нэг жилийн хугацаанд

/10-6/-аас хэтрэхгүй байхаар тооцно. Энэ талаар зохих журмын дагуу хяналтын байгууллагатай тохиролцсон байна

3.2.2 Үйлдвэр аж ахуйн нэгжийн норматив- техникийн баримт бичигт тэсрэлтийн аюулгүй байдлыг хангах аюулгүй байдлын коэффициентыг үйлдвэрлэлийн үйл ажиллагааны онцлогийг харгалзан тогтоосон байна.

3.2.3 Тэсрэлт үүссэнээс ажиллагсдад нөлөөлөх аюултай буюу хортой нөхцөл хүчин зүйлд :

- Цохилтын доргионы анхдагч даралтын хэмжээ зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрэх
- Барилга байгууламж, тоног төхөөрөмж, суваг хоолой, хийц бүтээцийн эвдэрч хэмхэрсэн болон бутарч шидэгдсэн хэсэг
- Эвдрэлийн улмаас тоног төхөөрөмжөөс ялгарсан хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ /ЗДХ/- нээс хэтрэх тохиолдлыг хамруулна.

3.2.4 Тэсрэх аюултай орчинд бодисын холимог / уур, тоос, хий/ нь агаар болон бусад / хүчилтөрөгч, азот, хлор, азотын исэл г.м/ исэлдүүлэгчтэй нэгдэх, тэсрэх хэлбэр лүү шилжсэн /ацетилен, азон, гидрозин г.м/ бодисууд үүсгэнэ.

3.2.5 Тэсрэлт үүсгэх үндсэн нөхцөл, шалтгаанд :

- Ил дөл, шатаж байгаа болон хайлж урсаж буй биет
- Цахилгаан цэнэг
- Механик үйлчлэл ба химийн урвалын дулаан ялгаруулалт
- Цохилт болон үрэлтийн улмаас оч хаягдах
- Цахилгаан долгион орно.

4 Тэсрэлт үүсэхээс урьдчилан сэргийлэх шаардлага

4.1 Тэсрэлт үүсэхээс урьдчилан сэргийлэхийн тулд тэсрэх аюултай орчин үүсэх нөхцөл бүрдүүлэхгүйн тулд гадна зохиомол тэсрэлт үүсгэгчийг бүрэн зогсоосон байна.

4.2 Үйлдвэрлэлийн байр орчны агаарт байх тэсрэх аюултай бодисуудын хувь, хэмжээ нь дөллөн асах хамгийн бага холимгийг хязгаараас /аюулгүй байдлын коэффициентыг тооцоод/ хэтрээгүй тохиолдолд тэсрэх аюултай орчин үүсэх нөхцөлийг бүрдүүлэхийн тулд хамгаалалтын хаалт бүхий тоног төхөөрөмж , ажлын болон аваарын салхивч хэрэглэх, тэсрэх аюултай орчин, бодисуудыг зайлуулах, агаарын орчны найрлага, тэсрэх аюултай тоосны үлдэгдэлд тогтмол хяналт тавих үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.3 Тоног төхөөрөмжийн дотор тэсрэх аюултай орчин үүсэхээс урьдчилан сэргийлэхэд түүний битүүмж, хаалт хамгаалалтыг бүрэн бүтэн байлгах, ажлын

байр талбайн болон гадна орчны үзүүлэлтийг тогтворжуулах, химийн урвал хурдасгагч буюу инертийн хий хэрэглэх, арга хэмжээ авна.

4.4 Үүссэн тэсрэлтийг идэвхжүүлэх эх үүсвэрийг таслан зогсооход :

- Гал унтраах ажлыг журамтай явуулах
- Тэсрэх аюултай орчны өөрөө асах температур хүртэл тоног төхөөрөмжийг халаахыг хориглох
- Анхдагч цохилтын долгионы даралт бууруулах хэрэгслийг ашиглах
- Долгионы цохилтын нөхцөлд оч үүсгэдэггүй материал хэрэглэх
- Тэнхлэг цахилгаанаас хамгаалах газардуулгыг хэрэглэх
- Тэсрэлтээс хамгаалагдсан тоног төхөөрөмж хэрэглэх
- Тэсрэлтийг идэвхжүүлэгч цахилгаан эх үүсвэрүүдийг таслах
- Цахилгаан соронзон болон туяаны үйлчлэлийг хязгаарлах
- Гаднын механик үйлчлэлийг багасгах арга хэмжээ авна

5 Тэсрэлт үүсэхээс хамгаалах арга хэмжээ

5.1 Тэсрэлт үүсэхээс хамгаалахын тулд :

- Тухайн үйлдвэрлэлд хэрэглэх тэсрэх аюултай бодисын шаардагдах хамгийн бага хэмжээг тогтоох
- Гал эсэргүүцэх хаалт, инертийн хийн болон уурын хөгшиг тусгаарлагч хэрэглэх
- Тэсрэх даралтын ачаалалд тохирсон тоног төхөөрөмж сонгож хэрэглэх
- Тэсрэх аюул бүхий үйл ажиллагааг тусгай зориулалтын байр, талбайд явуулах
- Урьдчилан сэргийлэх дохиоллын систем хэрэглэх арга хэмжээ авах.

6 Тэсрэлтийн аюулгүй байдлыг хангах техник зохион байгууллагын арга хэмжээ

6.1 Тэсрэлтийн аюулгүй байдлыг хангах техник зохион байгуулалтын арга хэмжээнд:

- Тэсрэлтийн технологийн заавар, тэсрэх аюултай бодис материалтай ажиллах дүрэм, журам болон ухуулан таниулах үзүүлэнгийн материалыг боловсруулж мөрдүүлэх
- Тэсрэлтийн аюулгүй ажиллагаа хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар ажилтан албан хаагчдад ажлын өмнө зааварчилга өгөх, сургалт зохион байгуулж байх
- Үйлдвэрлэлийн технологийн горим, галын аюулгүй болон ариун цэвэр, техник аюулгүй ажиллагааны дүрэм, нормын мөрдөлтөд тогтмол хяналт тавьж шалгалт хийх
- Аюул ослын үед ажиллах журам дарааллыг тогтоож урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах асуудлуудыг хамруулна.

7 Тэсрэлтийн үеийн аюулгүй ажиллагаанд тавих хяналт

7.1 Тэсрэх аюулгүй ажиллагаанд тавих хяналтын үндсэн объектод энэхүү стандартын 4.1, 4.2, 4.3, 4.4, 5.1, 6.1 заалтуудад тусгагдсан арга хэмжээ хамаарна.

7.2 Тухайн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны онцлогтой уялдуулан тэсрэлтийн

аюултай гол шинжүүдийг сонгож хяналт тавьж болно. Үүнд :

- Хий болон уурын холимгийг дөллөн асах хязгаар
- Тоос агаарын холимгийг дөллөн асах хамгийн бага хэмжээ
- Хялбар хайлах бодис ба шингэний дөллөн асах хязгаар хаалттай болон нээлттэй савны дотор агшин зуур асах температур
- Хялбар хайлах бодис ба шингэнүүдийн өөрөө асах температур
- Долгионы цохилтын мэдрэмж

7.3 Үйлдвэрлэлийн байр өрөө, тасалгааны агаарын найрлага дахь аюултай хорт бодисын тасралтгүй хуримтлал үүсэх байр, нөхцөл шалтгааныг шалгаж тогтоож байна.

ТӨГСӨВ.